



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 19

Баруун-Урт

“ӨСВӨРИЙН ЦАГДАА” БҮЛГЭМ
БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, хүүхдийг гэмт хэрэг зөрчилд өртөж хохирох болон холбогдохоос урьдчилан сэргийлэх ажилд Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон Ерөнхий боловсролын сургууль, Бүрэн дунд сургуулийн сурагчдын оролцоог нэмэгдүүлэх, сургуулийн дотоод дэг журмыг сахиулах, хүүхдүүдийн дунд Цагдаагийн байгууллагыг сурталчилж ирээдүйн Цагдаагийн байгууллагын алба хаагч бэлтгэх зорилгоор аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон сумдын Бүрэн дунд сургуулиудад “Өсвөрийн цагдаа” бүлгэмийг байгуулан ажиллуулсугай.

Хоёр: “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн ажиллах журмыг нэгдүгээр хавсралтаар, бүлгэмийн бэлгэдэл ялгах тэмдгийг хоёрдугаар хавсралтаар, гишүүдийн үнэмлэхний загварыг гуравдугаар хавсралтаар, хувцасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

Гурав: “Өсвөрийн цагдаа” бүлгэмийг мэргэжлийн удирдлагаар хангаж бүлгэмийн үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаар улиралд нэг удаа Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд танилцуулж байхыг Цагдаагийн газрын дарга /цагдаагийн хурандаа Ж.Батбаатар/-д даалгасугай.


Дөрөв: Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг бүх сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Я.МӨНХЖАРГАЛ



Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 сарын 31 –ны өдрийн 18 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



**ӨСВӨРИЙН ЦАГДАА БҮЛГЭМ
АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ**

Зорилго: Хүүхдийн эрх ашгийг хамгаалах, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирох болон холбогдохоос урьдчилан сэргийлэх ажилд Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон Бүрэн дунд сургууль, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын оролцоог нэмэгдүүлэх, сургуулийн дотоод дэг журмыг сахиулах, хүүхдүүдийн дунд Цагдаагийн байгууллагыг сурталчилж ирээдүйн Цагдаагийн алба хаагчийг бэлтгэхэд оршино.

**Нэг: “Өсвөрийн Цагдаа” бүлгэм байгуулах,
удирдлага, зохион байгуулалт**

1.1. Өсвөрийн цагдаагийн бүлгэмийн гишүүн нь өөрийн хүсэл сонирхлоороо элссэн байна.

1.2. Өсвөрийн цагдаагийн бүлгэмд сургуулийн сурагчдын тооноос хамааран бага, дунд, ахлах бүлэг тус бүрээс оролцуулан 13 сурагчийн бүрэлдэхүүнтэйгээр сургуулийн захирлын тушаалаар байгуулна.

1.3. Өсвөрийн цагдаагийн бүлгэмийн хувцасны загвар, ялгах тэмдэг, бэлгэдэл болон үнэмлэхний загварыг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор батална.

1.4. Өсвөрийн цагдаагийн бүлгэмийн тангаргийг Аймгийн Цагдаагийн газрын даргын тушаалаар баталж тангаргийг Цагдаагийн газраас зохион байгуулалттай, хүндэтгэлтэйгээр өргүүлэх ажлыг зохион байгуулна.

1.5. Аймгийн хэмжээнд ажиллаж байгаа Өсвөрийн цагдаагийн бүлгэмийн үйл ажиллагааг “Өсвөрийн цагдаагийн бүлгэмийн зөвлөл” нэгтгэнэ.

1.6. “Өсвөрийн цагдаагийн бүлгэмийн зөвлөл”-д бүлгэмүүдийн ахлагч, сургуулийн нийгмийн ажилтнууд, Цагдаагийн газрын Хүүхдийн байцаагч, Хүүхэд гэр бүлийн Хөгжлийн хэлтсийн хүүхдийн хууль зүйн хороо хариуцсан мэргэжилтэн нар байна.

1.7. Бүлгэмийн гишүүдийн хурлаар ахлагчийг сонгож, ахлагч бүлгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах ба бүлгийн гишүүд ахлагчийн шийдвэрт хүндэтгэлтэй хандана.

1.8. Өсвөрийн Цагдаагийн бүлгийн удирдлагыг бүлгийн ахлагч барина.

1.9. Бүлгийн бүх гишүүд улирал бүр хуралдаж хийсэн ажлаа дүгнэж дараагийн улиралд хийх ажлын төлөвлөгөөг гарган Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн даргаар батлуулах ба шаардлагатай тохиолдолд хурлыг нэн дариу зарлан хуралдуулж болно.

**Хоёр: Өсвөрийн цагдаагийн бүлгэмийн
ажиллах журам**

2.1 “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн гишүүд нь үйл ажиллагаагаа сургуулийн нийгмийн ажилтаны удирдлага дор явуулах ба Цагдаагийн газрын Хүүхдийн байцаагч /хэсгийн төлөөлөгч/ -аас мэргэжлийн туслалцаа зааварчилга авч ажиллана.

2.2 Сургуулийн дотоод дэг журмыг сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ухуулга яриа олон нийтийн ажил зохион байгуулна.

2.3 “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн гишүүд нь сургуулийн сурагчдаас гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, үйлдэж болзошгүй хүүхдүүдийн талаар мэдээлэл цуглуулж Цагдаагийн байгууллага /хүүхдийн байцаагч, хэсгийн төлөөлөгч/-д мэдэгдэх, тэдний үйлдлийг таслан зогсоох, хүмүүжүүлэх чиглэлээр зөвлөгөө, сэрэмжлүүлэг өгөх ажил зохион байгуулна.

2.4 Бүлгэмийн гишүүд нь сурагчдын эрх ашгийг хохироосон болон хохироож болзошгүй байгаа багш, ажилчид, иргэдийн талаарх мэдээллийг сургуулийн нийгмийн ажилтан, Цагдаагийн газрын хүүхдийн байцаагчид мэдэгдэнэ.

2.5 Сургуулийн сурагчдаас эрх зүйн зөрчил гаргасан сурагчдыг

2.5.1. “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх талаар саналыг холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.

2.5.2. Сургуулийн сурагчдын өөрөө удирдах байгууллага, ангийн хуралд шилжүүлэх.

2.5.3. Сургуулийн багш нарын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

2.6 Бүлгийн гишүүд нь баяр ёслол, олон нийтийн арга хэмжээний үеэр Цагдаагийн байгууллагын ажилтантай хамтран өдрийн цагаар нийтийн хэв журам сахиулах сурагчдын эргүүлд ажиллаж болно.

2.7 Орон нутгийн сонин хэвлэлд “Хүүхдийн хуулийн булан”-г эрхлэн гаргах, радио, телевизэд “Хүүхдийн оролцооны цаг” булан нэвтрүүлэг нээж сар бүр сурталчилгаа, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулна.

2.8 Өсвөрийн цагдаагийн бүлгэмийн ахлагч нь сард 1 удаа хийсэн ажлын талаар сургуулийн удирдлага болон Цагдаагийн газрын “Хүүхдийн алба”-д танилцуулж байна.

Гурав: “Өсвөрийн цагдаа” бүлгэмийн эрх хэмжээ

3.1 Өсвөрийн цагдаагийн бүлгэмийн гишүүд нь зөрчил гаргасан сурагчийг бүлгэмийн хурлаар хэлэлцээд гаргасан зөрчилд нийцүүлэн дараах шийдвэрээс сонгон гаргана.

- а. Сануулах
- б. Дахин зарчил гаргахгүй байх талаар амлалт авч баталгаа гаргуулах
- в. Анги хамт олны батлан даалтанд өгөх

Дөрөв: Дүгнэх, урамшуулах


4.1 Хичээлийн шинэ жилийн нэгдүгээр улиралд “Өсвөрийн цагдаа”-ийн бүлгэмүүдийн сургалтыг зохион байгуулан тухайн хичээлийн жилд хийх ажлын төлөвлөгөөг гаргана.

4.2 Гэмт хэргийн талаар хамгийн үнэтэй мэдээлэл олсон буюу идэвхи санаачлагатай ажилласан гишүүнийг мэдээллийн ач холбогдол, нотлогдсон байдал зэргийг харгалзан Цагдаагийн газраас урамшуулна.

4.3 бүлгэмд идэвхитэй сайн ажилласан гишүүдийн сурагчийн хувийн хэргийн тодорхойлолтонд тусгах саналыг сургуульд хүргүүлнэ.

4.4 Хичээлийн жилийн эцэст бүлгэмүүдийн цугларалтыг зохион байгуулж үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж шилдэг үйл ажиллагаатай нэг бүлгэм буюу удирдан ажилласан нийгмийн ажилтаныг шалгаруулж урамшуулах, шилдэг үйл ажиллагаатай бүлгийн үйл ажиллагааг сурталчилах ажил зохионо.


Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн
хурлын-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 сарын 3-ны
өдрийн 19 дугаар тогтоолын хавсралт



“Өсвөрийн цагдаа” бүлгэмийн Логоны загвар



Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 03 сарын 31-ны өдрийн 19 дугаар тогтоолын хавсралт



“Өсвөрийн цагдаа” бүлгэмийн гишүүний үнэмлэхний загвар



“ӨСВӨРИЙН ЦАГДАА”



Овог:
Нэр:

Сүхбаатар аймгийн
Цагдаагийн газрын
дэргэдэх “Өсвөрийн цагдаа”
бүлгэмийн гишүүн


НХЖХТ-ийн дарга, дэд хурандаа
/П. Лувсандорж/

ҮД: _____

СҮХБААТАР АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР

- Тус үнэмлэхийг Цагдаагийн алба хаагчийн хамт үүрэг гүйцэтгэхэд биедээ авч явна.
- Үнэмлэхийг бусдад шилжүүлэх болон барьцаанд тавихыг хориглоно.
- Үнэмлэхийг хаясан тохиолдолд 24 цагийн дотор Цагдаагийн газарт мэдэгдэнэ.

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 сарын 31-ны өдрийн 19 дугаар тогтоолын хавсралт



№	Хувцасны бүрдлийн нэр	Тоо ширхэг	Тайлбар
1	Малгай	1	
2	Хүрэм	1	
3	Подволк	1	
4	Өмд	1	
5	Хатгамал	Нэг бүрдэл хувцасны хатгамал	Малгай, хүрэм, подволк, өмдний хатгамал
НИЙТ			

“ӨСВӨРИЙН ЦАГДАА” БҮЛГЭМИЙН ГИШҮҮДИЙН ДҮРЭМТ ХУВЦАС

“Өсвөрийн цагдаа”-ийн хувцас нь малгай, хүрэм, подволк, өмдний бүрдэлтэй байна.

1. Малгай нь хавтгай оройтой, саравчтай байх бөгөөд урд хэсэгт 6 см-ийн голч бүхий “Сүхбаатар аймгийн Өсвөрийн цагдаа”-ийн бэлэгдэлтэй, хар хөх өнгөтэй байна.
2. Хүрэм нь сендпонон дотортой өвөл, хавар намрын куртка болон цамцан дээр өмсөх зориулалттай, ханцуйгүй байх бөгөөд урд талын зүүн энгэр дээр 6 см голч бүхий “Сүхбаатар аймгийн Өсвөрийн цагдаа”-ийн бэлэгдэлтэй, хүрэмний ар талд урт нь 27 см, өргөн нь 9,5 см хэмжээтэй “ӨСВӨРИЙН ЦАГДАА” бичигтэй байна.
3. Подволк нь хар өнгөтэй байх бөгөөд урд талын зүүн энгэр дээр 6 см голчтой “Сүхбаатар аймгийн Өсвөрийн цагдаа”-ийн бэлэгдэлтэй, ар талд урт нь 27 см, өргөн нь 9,5 см хэмжээтэй “ӨСВӨРИЙН ЦАГДАА” бичигтэй байна.
4. Өмд нь хөх цэнхэр өнгөтэй байх бөгөөд шуумагны ар талд резинтэй, хоёр талд ил болон далд карматай байна.